



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 2-р сарын 21-ний өдрийн 10:00 минутад Улаанбаатар хот, Аризона төв, 11 тоотод болов.

Хурлын дарга Ч.Чинзориг: “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн та бүхэнд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу тооллогын комиссын дарга Л.Идэрзаяа хурлын ирцийн талаар мэдээлэл өгнө үү.

Тооллогын комиссын дарга Л.Идэрзаяа: Миний бие Лхагвасүрэн овогтой Идэрзаяа компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар томилогдсон байгаа. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд хурлыг ирцийг танилцуулъя. 2020 оны 2 дугаар сарын 21 өдрийн 10:00 цагийн байдлаар нийт 9 хувьцаа эзэмшигч тус хуралд ирсэн байна. Хурлын ирц 50.55 % -тай байгаа тул хурлын ирцийг КТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.1 болон компанийн дүрмийн 9.1.4-т заасны дагуу хурал хүчин төгөлдөр хуралдах нөхцөл бүрдсэн байна.

Ч.Чинзориг: Хурлын ирцийг танилцуулсан Тооллогын комиссын даргад баярлалаа. Ирц бүрдсэн учраас компанийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдье.

Хурлын хэлэлцэх асуудлын дарааллын дагуу, эхлээд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг танилцуулах байгаа. ТУЗ-ийн Аудитын хорооны даргаар П.Чинзориг, гишүүд нь Ц.Билэг-Өрнөх, А.Даваазориг байгаа.

- Тайлант хугацаанд 335.4 сая төгрөгийн зардал гарч 626.6 сая төгрөгийн орлого орсон. Энэ хугацаанд дансны үлдэгдэл 12.2 сая, Үндсэн хөрөнгө нь 15.7 сая, хуримтлагдсан ашиг 269.9 сая төгрөгийн төсөвт үйл ажиллагаа явуулсан байна. Хорооны зүгээс нягтлан үзэхэд ямарваа нэгэн гомдол гаргаагүй, үйл ажиллагаа жигд сайн явагдсан гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд цаашдаа ТУЗ болон компанийн үйл ажиллагааны төсвийг батлах, үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэхэд хувьцаа эзэмшигчдээс компанийн удирдлагаас гаргаж буй саналыг дэмжиж өгөөч гэсэн зөвлөмжтэйгөөр аудитын хорооны дүгнэлтийг танилцуулж тус дүгнэлтийг баталж өгөхийг хүсье. Саналын хуудсаар та бүхэн эрхээ хэрэгжүүлнэ. Асуулт хариултыг дараа нь нэгтгээд авъя.
- Дараагийн асуудал бол Хараат бус Аудитын дүгнэлт байгаа аудитын дүгнэлтийг “Мэжик Консалтинг Аудит” ХХК-иар хийлгэсэн. Өнгөрсөн онд татварын мэргэшсэн зөвлөх болох Лидер Финанс компанитай хамтран ажиллаад сар тутмынхаа үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хэлбэрээр татварын зөвлөхтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ үйл ажиллагаагаа цаашдаа тогтвортой явуулж байх бодлоготой байгаа. Энэ нь компанийн үйл ажиллагаанаас гадна харилцагчид, хамтран ажилладаг байгууллагуудад мэдээлэл нь маш зөв зүйтэй хүрэх, тайлагнагдаж байна. Энэ үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлнэ. Хараат бус аудитын дүгнэлтийн материал нь мөн та бүхэнд тараагдсан байгаа учраас дэлгэрэнгүй танилцуулсангүй. Аудитын дүгнэлтэд ямарваа нэг сөрөг дүгнэлт байхгүй. Үйл ажиллагаа амжилттай сайн явагдсан гэсэн дүгнэлт байгаа.
- Дараагийн асуудал бол ТУЗ-ийн 1 тоот тогтоолыг батлах тухай танилцуулах байгаа. Энэ тогтоол нь ногдол ашиг хувиарлахгүй. Ямар зорилготой гэвэл дүрмийн сангаа

нэмэгдүүлж гэсэн саналтай байгаа. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 441 тоот тогтоолоор нийт 500 гаруй ББСБ тэр дундаа Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж буй 400 гаруй ББСБ-ийн дүрмийн санг 2020 онд 1.9 тэрбум, 2021 онд 2.5 тэрбум төгрөгийн дүрмийн сантай байх шаардлагыг тавьсан. Дээрх шаардлагыг биелүүлэх үүднээс манай компанийн хувьд өнгөрсөн онд хуримтлагдсан нийт ашиг болох 269.9 сая төгрөгөөр 100 хувь компанийн дүрмийн сангаа нэмэгдүүлэх зорилготой. Ийм учраас 2019 онд компанийн үйл ажиллагааны ашгаас олсон орлогыг ногдол ашиг хувиарлахгүй байхаар санал оруулаад ТУЗ-өөс ногдол ашиг хувиарлахгүй байх тогтоол гарсан байгаа.

- Дараагийн асуудал бол үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах асуудал байгаа. Манай компани нь Зээлийн, Гадаад валютын, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх гэсэн үйл ажиллагаатай байгаа. Валютын үйл ажиллагаа бол өндөр эрсдэлтэй учраас бидний хувь энэ үйл ажиллагааг өргөжүүлэх үүднээс одоогоор үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байна. Хөрөнгө оруулалтын чиглэлээр бол зохих ажлуудыг нэг бус удаа хийсэн. Зээлийн үйл ажиллагаа бол тогтвортой явагдаж байгаа. Нэмж авах үйл ажиллагаа нь Итгэлцлийн үйлчилгээ, Факторингийн үйлчилгээ, Төлбөрийн баталгаа гаргах гэсэн эдгээр үйл ажиллагааны чиглэлүүд байгаа. Итгэлцлийн үйлчилгээг яагаад явуулахыг зорьж байна вэ гэхлээр өнгөрсөн оны ашиг тодорхой хувиар өмнөх жилүүдээс буурсан тийм учраас хөрөнгийн эх үүсвэрээ тогтвортой нэмж байх, шаардлагатай үед богино, урт хугацаатай, дунд хугацааны зээл итгэлцлээр авах зорилготойгоор та бүхний гар дээр тараасан материал дээр оруулсан байгаа. Та бүхийг энэ үйл ажиллагааг авахыг дэмжихийг хүсэж байна. Дараагийн үйл ажиллагаанд бол Факторинг, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ байгаа эдгээр үйл ажиллагаа нь мөн л үйл ажиллагаагаа өргөжүүлэх, үр ашгаа нэмэгдүүлэх зорилготой байгаа.
- Дараагийн асуудал бол салбар нээх асуудал байгаа. Завхан аймагт салбар нээх зөвшөөрөл авсан боловч тухайн орон нутагтаа хэлэлцэж тохиролцсон ажлаа хэрэгжүүлэхэд түншлэгчээр ажиллах байсан нэгж байгууллага нь яг одоо зах зээл хумигдсан энэ үе учир одоогоор нээх шаардлагагүй, хэсэг хугацаанд харзана гэсэн санал тавьсан учраас Завхан аймагт салбар нээгээгүй байгаа. Салбар энэ онд нэмж байгуулахын хувьд бол тодорхой хэмжээний нэмэлт хөрөнгө оруулалт татна, дараа нь итгэлцлийн үйлчилгээ, факторинг, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээнээс тодорхой хэмжээний нэмэлт хөрөнгө оруулалт татах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх учраас салбар байгуулья гэсэн бодолтой байгаа. Бидний судалгаагаар Улаанбаатарт 490 ББСБ-ын үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Чингэлтэй дүүрэгт 26,9 хувь, зэргэлдээ Сүхбаатар дүүрэгт 29,3 нийтдээ энэ 2 дүүрэгт 60 хувь орчим нь төвлөрсөн байдаг. Тийм учраас бид бүхэн Сонгинохайрхан дүүргийн авто комплекс дээр салбар нээх гэсэн бодол байна. Өөрөөр хэлбэл Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх эдгээр дүүргүүдэд салбар нээх гэсэн саналтай байгаа. Эдгээр 3 дүүрэг нийлээд 10 гаран хувьтай байгаа тэгэхээр энэ дүүргүүдэд салбар нээх тухай асуудлыг та бүхнээр шийдвэрлүүлэхийг хүсэж байгаа юм.
- Дараагийн асуудал бол нэмэлт хувьцаа гаргах байгаа. 1-рт хөрөнгийн эх үүсвэр дутагдаж байгаа, 2-рт Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс хувьцааны төвлөрлийг багасгах тухай асуудлыг тавьж байгаа тийм учраас нэмэлт хувьцаа гаргах замаар хөрөнгө оруулагчийг нэмэгдүүлэх хувьцааны арилжааг нэмэгдүүлэх үүднээс ирэх онд энгийн хувьцааг 30 хувиар нэмэгдүүлэх зорилготой байгаа. Өмнөх онд хэлэлцсэн давуу эрхийн хувьцааг өнгөрсөн онд хэрэгжүүлж чадаагүй. Тийм учраас энэ онд гаргахаар төлөвлөсөн байгаа. Өрийн бичиг гарах тухай компанийн бонд СЗХ, МХБ, КТХ заагдсаны дагуу манай компани хаалттай

хүрээнд гаргах хүсэлтэй байгаа. Дүрэм журмын дагуу 50 хүртэлх хувиар бонд гаргах боломжтой! тэрбум хүртэлх өрийн бичиг гаргах асуудлыг шийдэж өгнө үү.

- Дараагийн асуудалд компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудал байгаа. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, дүрмийн сан нэмэгдүүлэх, хувь эзэмшлийн хэмжээнд өөрчлөлт оруулах, ТУЗ-тай холбоотой эдгээр асуудлуудыг компанийн дүрэмд нэмэлтээр оруулах хүсэлтэй байна.
- Дараагийн асуудал нь ТУЗ-ын төсөл батлах асуудал байгаа. Бусад компаниудын хувьд улиралд нэг удаа хуралдсан тохиолдолд цалин өгдөг. Энэ тохиолдолд бид татварын мэргэшсэн зөвлөхтэй зөвшилцөөд сар тутам өгөх нь зөв гэж зөвлөлдсөн учир өнгөрсөн онд цалингаа өгсөн, энэ онд мөн адил цалингийн доод хэмжээгээр цалингаа өгөөд явах бодолтой байгаа.
- Дараагийн асуудал нь компанийн 2020 оны зардлын төсөв батлах байгаа. 463,700 сая төгрөг төсөвлөсөн байгаа. Энэ ажлынхаа хүрээнд бид бүхэн дээрх зөвшөөрлүүдийг авах, зөвшөөрлүүдийг авсантай холбогдуулан үйл ажиллагаагаа өргөтгөх энэ төсвийг бид бүхэн танилцуулж байгаа

Ингээд хэлэлцэх асуудал танилцуулагдаад дуусаж байна. Та бүхэнд асуулт байвал асуугаад, саналынхаа хуудсаар саналын эрхээ хэрэгжүүлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Хувьцаа эзэмшигч Л.Тунгалаг: Сайн байна уу. Хувьцаа эзэмшигч Тунгалаг байна. Ногдол ашгийн талаар асууж тодруулах зүйл байна. Энэ жил ногдол ашиг тараахгүй дүрмийн санг нэмэгдүүлэх юм байна ирэх жилээс ногдол ашиг хуваарилна гэсэн төлөвлөгөөтэй байгаа юу эсвэл дахиад дүрмийн сангаа нэмэгдүүлж, зээлийн багцаа өсгөх төлөвлөгөөтэй байгаа юу?

Ч.Чинзориг: Энэ жилдээ амжилттай хөрөнгө оруулалт татан Санхүүгийн зохицуулах хорооноос үүрэг болгосон дүрмийн сангийн хэмжээг 2.5 тэрбум төгрөгийг хангахаар ажиллана ирэх жилээс эхлэн тогтмол цэвэр ашгаасаа ногдол ашиг хуваарилах төлөвлөгөөтэй байгаа.

Хувьцаа эзэмшигч Ж.Ганзориг: Сайн байна уу. Хувьцаа эзэмшигч Ганзориг байна. Нэмэлт хувьцаа болон Бондыг яагаад хаалттай хүрээнд гаргах гэж байгаа вэ?

Ч.Чинзориг: Хэд хэдэн давуу талууд бий.

Нэгдүгээрт хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах нь нээлттэй хүрээнд гаргаснаас зардал багатай.

Хоёрдугаарт Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн шаардах материал нь харьцангуй бага байдаг. Манай компанийн хувьд энэ жилдээ багтаан нэмэлт хөрөнгө оруулах ёстой байгаа учир арай хялбар аргыг сонгосон.

Гуравдугаарт Стратегийн хөрөнгө оруулагч, гадаадын байгууллагын мэргэшсэн хөрөнгө оруулагч нарт санал тавьсан.

Ч.Чинзориг: Хувьцаа эзэмшигч нараас нэмж хэлэх санал, асуух асуулт байна уу? Байхгүй бол Тооллогын комисс саналын хуудсаа хурааж аваад тооллогын дүнг гаргаад танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Л.Идэрзаяа байна: 2020 оны 2-р сарын 21-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудын саналын дүнг танилцуулъя

Хэлэлцэх асуудал 1: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 3: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 4: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 5: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 6: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 7: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 8: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 9: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 10: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 11: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 50,55 %-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100% ийн саналаар батлагдлаа.

Хурлын дарга Ч.Чинзориг: Нийт хэлэлцсэн асуудлууд санал хураалтын тооллогын дүнгээр 50,55 % буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдсан байна. Тогтоолын төслийг танилцуулаад батлаад явъя гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нийт 9 тогтоол баталлаа.

Хурал хаасныг мэдэгдье: 11:45 минут

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

/Хурлын нарийн бичгийн дарга/

М. Нандинцэцэг

/Н.Нандинцэцэг/

Баталсан:

/Хурлын дарга/



Ч. Чинзориг

/Ч.Чинзориг/